

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр

Дугаар А/27/А/25 Улаанбаатар хот

“Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөө /2024-2027/
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл шүд” арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)-г нэгдүгээр, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/, Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар /А.Өнөржаргал/, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар, Дээд боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар /Х.Тамир/, Мэргэжлийн болон техникийн боловсролын газар /А.Халиунаа/-т тус тус үүрэг болгосугай.


3. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар /Ш.Энхтуяа/, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Л.Бямбасүрэн/, Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газар, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Нүүр ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл /Ч.Гантөмөр/, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа Нүүр ам судлалын сургууль /Б.Батбаяр/, Монголын шүдний мэргэжилтний холбоо /Т.Учрал/-нд тус тус үүрэг болгосугай.

4. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөл болон олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт тусган санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газар /Л.Лувсан/, Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Б.Батцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

5. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэн жил бүрийн 1 дүгээр сард багтаан танилцуулж байхыг Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газар, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газарт тус тус үүрэг болгосугай.

6. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Н.Нарангэрэл/-т тус тус даалгасугай.





Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2024 оны 04 дүгээр сарын 19 -ны өдрийн 424/А.5 дугаар
хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

"ЭРҮҮЛ ШҮД" 2024-2027 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго:

Амны хөндийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулан, урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах замаар амны хөндийн эмгэгийг бууруулах

Зорилт:

1. Амны хөндийн эрүүл мэндийн бодлого, эрх зүйн орчныг сайжруулах;
2. Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, эмгэгээс урьдчилан сэргийлэх;
3. Нүүр ам судлалын салбарын хүний нөөцийг дэмжих чадавхыг бэхжүүлэх;
4. Анхан шатны тусламж, үйлчилгээнд Нүүр амны тусламж үйлчилгээг нэвтрүүлэх;
5. Нүүр амны тусламж, үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй хүргэх;
6. Амны хөндийн эмгэгийн бүртгэл, тандалтын тогтолцоог бэхжүүлэх.

дд	Арга хэмжээ	Эх үүсвэр	2024-2027 оны нийт төсөв (сая төг)	Суурь түвшин	Хүрэх түвшин, үр дүн, төсөв						Хэрэгжүүлэх байгууллага			
					2024 он		2025 он		2026 он		2027 он		Үндсэн	Хамтрагч
					Хүрэх түвшин	Төсөв (сая төг)	Хүрэх түвшин	Төсөв (сая төг)	Хүрэх түвшин	Төсөв (сая төг)	Хүрэх түвшин	Төсөв (сая төг)		
Зорилт 1: Амны хөндийн эрүүл мэндийн бодлого, эрх зүйн орчныг сайжруулах														
1.1	Улсын хэмжээнд амны хөндийн эрүүл мэндийн илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, сургалт, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий үндэсний төвийг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагыг түшиглэн байгуулах	ОУБ, Хариуцах байгууллагын төсөв	70.0	-	Үндэсний төв байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох тогтоолыг батлуулсан байна. Шаардлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ.	10.0	Төвийн багаж, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, хүний нөөцийг чадавхжуулсан байна.	20.0	Төвийн багаж, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, хүний нөөцийг чадавхжуулсан байна.	20.0	Төвийн багаж, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, хүний нөөцийг чадавхжуулсан байна.	20.0	ЭМЯ	НЗДТГ, НЭМГ, НШЭНТ
1.2	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, боловсрол олгох тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх	ЭМДС, төсөв	1,000.0	100.0	Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтийн 5-аас доошгүй хувийг амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, боловсрол олгох үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.	250.0	Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтийн 5-аас доошгүй хувийг Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, боловсрол олгох үйл ажиллагаанд зарцуулдаг болсон байна.	250.0	Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтийн 5-аас доошгүй хувийг Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, боловсрол олгох үйл ажиллагаанд зарцуулдаг болсон байна.	250.0	Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтийн 5-аас доошгүй хувийг Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, боловсрол олгох үйл ажиллагаанд зарцуулдаг болсон байна.	250.0	ЭМЯ, АЗДТГ, НЗДТГ	-
1.3	Хүүхдийн шүд, амны хөндийн үзлэг, оношилгоо, эмчилгээний бүртгэл мэдээллийг салбар хооронд солилцох эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн мэдээллийн санг байгуулах	ОУБ	650.0	-	Салбар хоорондын мэдээлэл солилцоход бэлтгэл ажлыг ханган, шаардлагатай журам, зааврыг боловсруулсан байна.	100.0	Салбар хоорондын цахим мэдээллийн нэгдсэн системийг үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн байна.	500.0	Салбар дундын цахим мэдээллийн нэгдсэн системийг үйл ажиллагаанд ашиглаж үр дүнтэй тооцож эхэлсэн байна.	30.0	Салбар дундын цахим мэдээллийн нэгдсэн системийг үйл ажиллагаанд ашиглаж сургууль, цэцэрлэгүүдэд нэвтрүүлсэн байна.	20.0	ЭМЯ, НЭМГ, АЭМГ	БШУЯ, НЭМГ, АЭМГ, НАСС, МШМНХ, АЗДТГ, НЗДТГ
1.4	Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага бүх нийтийн амны хөндийн эрүүл мэндийг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалт хийх санаачилгыг дэмжих.	-	-	-	Төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад салбарын оролцоог хангах, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх нөлөөллийн ажил явуулсан байна.	-	Төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад салбарын оролцоог хангах, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх нөлөөллийн ажил явуулсан байна.	-	Төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад салбарын оролцоог хангах, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх нөлөөллийн ажил явуулсан байна.	-	Төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад салбарын оролцоог хангах, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх нөлөөллийн ажил явуулсан байна.	-	ЭМЯ, НЭМГ, АЭМГ	БШУЯ, НЗДТГ, МШМНХ, НАССМСЗ

Зорилт 2. Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, эмгэгээс урьдчилан сэргийлэх														
2.1	Амны хөндийн эмгэг үүсгэгч эрсдэлт хүчин зүйлийг бууруулах санаачилгыг дэмжих, иргэдэд чиглэсэн аянг зохион байгуулах	Эрүүл мэндийг дэмжих сан, ОУБ, АЗДТГ, НЗДТГ	600.0	2023 онд Налайх болон Нийслэлийн ЕБС-ийн дунд 2 удаа зохион байгуулсан	Иргэдийн дунд тамхи, архины хортой хэрэглээ, чихэр, өөх тос, давс ихтэй хоолны дэглэм зэрэг нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, батлуулсан байна.	150.0	Иргэдийн дунд тамхи, архины хортой хэрэглээ, чихэр, өөх тос, давс ихтэй хоолны дэглэм зэрэг нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан байна.	150.0	Иргэдийн дунд тамхи, архины хортой хэрэглээ, чихэр, өөх тос, давс ихтэй хоолны дэглэм зэрэг нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан байна.	150.0	Иргэдийн дунд тамхи, архины хортой хэрэглээ, чихэр, өөх тос, давс ихтэй хоолны дэглэм зэрэг нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан байна.	150.0	НЭМУТ, НЭМГ, АЭМГ	ЭМЯ, АЗДТГ, НЗДТГ, НАСС, НАСМСЗ, МШМНХ
2.2	Хүүхдийн шүдний урьдчилсан сэргийлэх үзэлтг хамруулах, шүдийг эрдэсжүүлэх аянг зохион байгуулах.	ЭМДС, АЗДТГ, НЗДТГ	200.0		Хүүхдийн шүдийг нэмэлтээр эрдэсжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Шүдийг эрдэсжүүлэх үйл ажиллагаа болон фтороор баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний талаар судлах, уулзалтуудыг зохион байгуулна.	50.0	Хүүхдийн шүдийг нэмэлтээр эрдэсжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	50.0	Хүүхдийн шүдийг нэмэлтээр эрдэсжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	50.0	Хүүхдийн шүдийг нэмэлтээр эрдэсжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	50.0	НЭМГ, АЭМГ, НАСС-ын сургуулиуд	ЭМЯ, АЗДТГ, НЗДТГ, НАСМСЗ, МШМНХ
2.3	Фторын зохистой хэрэглээг зохицуулах (Усны шүүлтүүр)	ОУБ, АЗДТГ, НЗДТГ	40.0	-	Ундны усанд фторын агууламж өндөр нутаг дэвсгэрт зохицуулах арга хэмжээ авсан байна.	10.0	Ундны усанд фторын агууламж өндөр нутаг дэвсгэрт зохицуулах арга хэмжээ авсан байна.	10.0	Ундны усанд фторын агууламж өндөр нутаг дэвсгэрт зохицуулах арга хэмжээ авсан байна.	10.0	Ундны усанд фторын агууламж өндөр нутаг дэвсгэрт зохицуулах арга хэмжээ авсан байна.	10.0	ЭМЯ, НЭМГ, АЭМГ	АЗДТГ, НЗДТГ, НАСС, НАСМСЗ, МШМНХ, ОУБ
2.4	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг бүх шатны боловсролын байгууллагад хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих цэцэрлэг, ЕБС-ийг хөгжүүлэх санаачилгыг өрнүүлэх	ОУБ Хариу цах байгуулагын төсөв	20.0	-	"Хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих удирдамж" боловсруулсан байна.	5.0	"Хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих удирдамж"-ийг хэрэгжүүлэн, хүүхдэд шүд угаах зан үйлийг төлөвшүүлсэн байна.	5.0	"Хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих удирдамж"-ийг хэрэгжүүлэн, хүүхдэд шүд угаах зан үйлийг төлөвшүүлсэн байна.	5.0	"Хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих удирдамж"-ийг хэрэгжүүлэн, хүүхдэд шүд угаах зан үйлийг төлөвшүүлсэн байна.	5.0	БШУЯ, ЭМЯ, БЕГ	АЗДТГ, НЗДТГ, НБГ, АБШУГ, НЭМГ, АЭМГ, ОУБ
2.5	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын орчинд шүд угаах орчныг үе шаттай бүрдүүлэх, сургалтын байгууллагын орчинд шүд угаах цагийн зохицуулалтыг хийж, сурагчдад шүд угаах зан үйлийг төлөвшүүлэх	Улсын төсөв, НҮБ-ын ХС, ОУБ	6,486.0	Нийслэлд 2 ЕБС (ЧД 50-р, 37-р сургууль	Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежид шүд угаах зориулалт бүхий ариун цэврийн угаалтууртай 90 цэг байгуулж, өдөр бүр үдийн цайны дараа "Шүд угаах цаг"-ийг зохион байгуулдаг болсон байна.	1,350.00	Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежид шүд угаах зориулалт бүхий ариун цэврийн угаалтууртай 114 цэг байгуулж, өдөр бүр үдийн цайны дараа "Шүд угаах цаг"-ийг зохион байгуулдаг болсон байна.	1,712.00	Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежид шүд угаах зориулалт бүхий ариун цэврийн угаалтууртай 114 цэг байгуулж, өдөр бүр үдийн цайны дараа "Шүд угаах цаг"-ийг зохион байгуулдаг болсон байна.	1,712.00	Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежид шүд угаах зориулалт бүхий ариун цэврийн угаалтууртай 114 цэг байгуулж, өдөр бүр үдийн цайны дараа "Шүд угаах цаг"-ийг зохион байгуулдаг болсон байна.	1,712.00	БШУЯ, АЗДТГ, НЗДТГ, БЕГ,	ЭМЯ, НЭМГ, АЭМГ, НБГ, АБШУГ, НАСС, НАСМСЗ, МШМНХ, ОУБ
2.6	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн боловсролын сургалтын хөтөлбөрт заасан амны хөндийн эрүүл ахуй сахих, шүдийг хэрхэн зөв угаах дадал, хэвшилд сургах чиглэлээр сургалтын макет, үзүүлэнгээр хангах, цахим контент хөгжүүлэх.	Улсын төсөв, ОУБ	4,000.0	-	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 25 хувийг сургалтын макет, үзүүлэнгээр хангасан байна.	1,000.0	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 50 хувийг сургалтын макет, үзүүлэнгээр хангаж, цахим контент 10-ийг хөгжүүлсэн байна.	1,000.0	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 75 хувийг сургалтын макет, үзүүлэнгээр хангаж, цахим контент 20-ийг хөгжүүлсэн байна.	1,000.0	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг сургалтын макет, үзүүлэнгээр бүрэн хангаж, цахим контент 30-ыг хөгжүүлсэн байна.	1,000.0	БЕГ, НЭМГ, АЭМГ, НБГ, АБШУГ,	ЭМЯ, БШУЯ, АЗДТГ, НЗДТГ, НАСС, НАСМСЗ, МШМНХ, ОУБ

2.7	Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчнөөс сэргийлэх талаар анагаахын шинжлэх ухаан, нүүр ам судлалын чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулдаг сургууль багш бэлтгэдэг төрийн өмчийн их сургуулийн сонгон судлах хичээлийн сургалтын агуулга, хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх, ЕБС, СӨББ-ын багш нарыг чадавхижуулах	Улсын төсөв, ОУБ	-	-	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, багш бэлтгэдэг төрийн өмчийн нэг их сургуулийн сонгон судлах хичээлийн сургалтын хөтөлбөрт амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар агуулгыг тусгасан байна.	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, багш бэлтгэдэг төрийн өмчийн хоёр их сургуулийн сонгон судлах хичээлийн сургалтын хөтөлбөрт амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтын агуулга, хөтөлбөрт тусгах нөлөөллийн ажлыг явуулж, ЕБС, цэцэрлэгийн багш нарын 50 хувийг сургалтад хамруулсан байна	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, багш бэлтгэдэг төрийн өмчийн гурван их сургуулийн сонгон судлах хичээлийн сургалтын хөтөлбөрт амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтын агуулга, хөтөлбөрт тусгах нөлөөллийн ажлыг явуулж, ЕБС, цэцэрлэгийн багш нарын 70 хувийг сургалтад хамруулсан байна	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, багш бэлтгэдэг төрийн өмчийн дөрвөн их сургуулийн сонгон судлах хичээлийн сургалтын хөтөлбөрт амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтын агуулга, хөтөлбөрт тусгах нөлөөллийн ажлыг явуулж, ЕБС, цэцэрлэгийн багш нарын 100 хувь сургалтад хамруулсан байна		БЕГ, НЭМГ, АЭМГ, НБГ, АБШУГ,	ЭМЯ, БШУЯ, АЗДТГ, НЗДТГ, НАСС, НАСМСЗ, МШМНХ, ОУБ
2.8	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийг татан оролцуулах олон нийтийн хөдөлгөөнийг өрнүүлэх	ОУБ, Хариуцах байгууллагын төсөв	80.0	-	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн гишүүдийг татан оролцуулах олон нийтийн хөдөлгөөнийг өрнүүлэх нөлөөллийн ажлыг 20 ерөнхий боловсролын сургуульд явуулсан байна.	20.0	20.0	20.0	20.0	НЭМГ, АЭМГ, НАСС, НАСМСЗ, МШМНХ, НАСС-ын сургуулиуд	ЭМЯ, БШУЯ, АЗДТГ, НЗДТГ, ОУБ
2.9	Ажлын байранд суурилсан амны хөндийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, "Шүд угаах цаг"-ийг хэрэгжүүлэх.	Хариуцах байгууллагын төсөв	20.0	-	Ажлын байранд суурилсан амны хөндийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр боловсруулж, батлуулсан байна. Шүд угаах цагийг 5 ажлын байранд хэрэгжүүлж эхэлсэн байна.	5.0	5.0	5.0	5.0	ЭМЯ, АЗДТГ, НЗДТГ	ХНХЯ, НЭМГ, АЭМГ, НАСС, НАСМСЗ, МШМНХ, ОУБ
2.10	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих олон нийтэд түшиглэсэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Аймаг, нийслэлийн төсөв, ОУБ	90.0	-	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих олон нийтэд түшиглэсэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлагдсан байна.	30.0	20.0	20.0	20.0	НЭМГ, АЭМГ, МШМНХ,	НЭМГ, АЭМГ, НАСС, НАСМСЗ, ОУБ
2.1	Амны хөндийн эмгэгийг эрт илрүүлэх, оношлох, эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэхэд дижитал технологийг ашиглах.	Улсын төсөв, ОУБ	210.0	-	Амны хөндийн эрүүл мэндийн дижитал технологи, гар утасны аппликейшн ашиглан хувь хүн, олон нийт, бодлого боловсруулагчид, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллага руу чиглэсэн сургалт сурталчилгаа, мэдээллийн агуулгыг боловсруулж, батлуулан түгээж эхэлсэн байна.	30.0	60.0	60.0	60.0	НЭМГ, АЭМГ, НАСС	ЭМЯ, АЗДТГ, НЗДТГ, НАСМСЗ, МШМНХ, ОУБ

2.1	Амны хөндийн эрүүл мэндээ иргэд өөрсдөө хянах, шүд цоорох өвчний хүндрэлээс сэргийлэх мэдлэг, дадал олгох сургалт сурталчилгаа явуулах	Улсын төсөв, ОУБ	40.0	-	Амны хөндийн эрүүл мэндээ иргэд өөрсдөө хянаж дээшлүүлэх, шүд цоорох өвчний хүндрэлээс сэргийлэх мэдлэг, дадал олгох сургалт сурталчилгаа явуулсан байна.	10	Амны хөндийн эрүүл мэндээ иргэд өөрсдөө хянаж дээшлүүлэх, шүд цоорох өвчний хүндрэлээс сэргийлэх мэдлэг, дадал олгох сургалт сурталчилгаа явуулсан байна.	10	Амны хөндийн эрүүл мэндээ иргэд өөрсдөө хянаж дээшлүүлэх, шүд цоорох өвчний хүндрэлээс сэргийлэх мэдлэг, дадал олгох сургалт сурталчилгаа явуулсан байна.	10	Амны хөндийн эрүүл мэндээ иргэд өөрсдөө хянаж дээшлүүлэх, шүд цоорох өвчний хүндрэлээс сэргийлэх мэдлэг, дадал олгох сургалт сурталчилгаа явуулсан байна.	10	НЭМГ, АЭМГ, НАСС-ын сургуулиуд	ЭМЯ, НАСМСЗ, МШМНХ, ОУБ
Зорилт 3. Нүүр ам судлалын салбарын хүний нөөцийг дэмжих, чадавхыг бэхжүүлэх														
3.1	Шүдний эмч, нүүр амны эрүүл ахуйч бэлтгэх сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийж, шинэчлэх	Хариуцсан байгууллага, ОУБ	20.0	-	Нүүр ам судлалын мэргэжлээр бакалаврын түвшний боловсрол олгож буй хувийн болон улсын сургуулийн сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийсэн байна. Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, нийгмийн эрүүл мэнд, эмгэгээс урьдчилан сэргийлэлт, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт чиглэлээр хичээл нэмж оруулсан байна.	15.0	Сайжруулсан хөтөлбөрийг ИДС, МБСБ-ууд хэрэгжүүлсэн байна. Сургалтын хөтөлбөрт Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, нийгмийн эрүүл мэнд, эмгэгээс урьдчилан сэргийлэлт, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт чиглэлээр хичээл ордог болсон байна.	5.0	Нүүр ам судлалын мэргэжлээр бакалаврын түвшний боловсрол олгож буй хувийн болон улсын сургуулийн сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлсэн байна.	-	Үнэлгээний зөвлөмжийн дагуу хөтөлбөрийг сайжруулсан байна.	-	БШУЯ, ЭМЯ	НАСМСЗ, МШМНХ
3.2	Нүүр амны тусламж үйлчилгээ үзүүлэх эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах	Хариуцсан байгууллага, ОУБ	800.0	Сургалтанд хамрагдсан 400 эмч	Нүүр амны их эмч нарыг чадавхжуулах, эрүүл ахуйч, шүдний туслагч нарыг дэмжих эрх зүйн орчин бий болгох; ЕБС, СӨБ, Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилчдыг чадавхжуулах сургалтад хамруулж ажилчдыг чадавхжуулах сургалтад хамруулж эхэлсэн байна. 40 олон нийтийн эрүүл мэндийн ажилтныг амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр бэлтгэх сургалтад хамруулсан байна.	200.0	ЕБС, СӨБ, Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилчдыг чадавхжуулах сургалтад хамруулсан байна. 40 олон нийтийн эрүүл мэндийн ажилтныг амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр бэлтгэх сургалтад хамруулсан байна.	200.0	ЕБС, СӨБ, Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилчдыг чадавхжуулах сургалтад хамруулсан байна. 40 олон нийтийн эрүүл мэндийн ажилтныг амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр бэлтгэх сургалтад хамруулсан байна.	200.0	ЕБС, СӨБ, Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилчдыг чадавхжуулах сургалтад хамруулсан байна. 40 олон нийтийн эрүүл мэндийн ажилтныг амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр бэлтгэх сургалтад хамруулсан байна.	200.0	ЭМХТ, НАСС, МШМНХ	ЭМЯ, НЭМГ, АЭМГ, НАСМСЗ, ОУБ
3.3	Нүүр ам судлалын салбарын эмч, мэргэжилтнүүдийг нийгмийн эрүүл мэнд, менежмент, манлайлын чиглэлээр бэлтгэх	Улсын төсөв, ОУБ	400.0	байхгүй	Нүүр ам судлалын эмч, мэргэжилтэн 5 хүнийг нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн бодлого, менежмент, манлайлын чиглэлээр бэлдэх, чадавхжуулах, сургалтад хамруулсан байна.	100.0	Нүүр ам судлалын эмч, мэргэжилтэн 5 хүнийг нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн бодлого, менежмент, манлайлын чиглэлээр бэлдэх, чадавхжуулах, сургалтад хамруулсан байна.	100.0	Нүүр ам судлалын эмч, мэргэжилтэн 5 хүнийг нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн бодлого, менежмент, манлайлын чиглэлээр бэлдэх, чадавхжуулах, сургалтад хамруулсан байна.	100.0	Нүүр ам судлалын эмч, мэргэжилтэн 5 хүнийг нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн бодлого, менежмент, манлайлын чиглэлээр бэлдэх, чадавхжуулах, сургалтад хамруулсан байна.	100.0	ЭМХТ	ЭМЯ, АЭМГ, НЭМГ, ОУБ

3.4	Сувилагч, эрүүл ахуйч, техникч, олон нийтийн эрүүл мэндийн ажилчдад зориулсан амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, чадавжуулах сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	ОУБ	45.0	-	Сувилагч, эм зүйч, техникч, олон нийтийн эрүүл мэндийн ажилчдад зориулсан амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, чадавжуулах сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулж, сургалтыг зохион байгуулж эхэлсэн байна.	20.0	Сувилагч, эм зүйч, техникч, олон нийтийн эрүүл мэндийн ажилчдад зориулсан амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, чадавжуулах сургалтыг зохион байгуулсан байна.	15.0	Сувилагч, эм зүйч, техникч, олон нийтийн эрүүл мэндийн ажилчдад зориулсан амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, чадавжуулах сургалтыг зохион байгуулсан байна.	5.0	Сувилагч, эм зүйч, техникч, олон нийтийн эрүүл мэндийн ажилчдад зориулсан амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, чадавжуулах сургалтыг зохион байгуулсан байна.	5.0	ЭМХТ, МШМНХ, НАСС	ЭМЯ, НЭМГ, АЭМГ, НАСМСЗ, ОУБ
3.5	Нүүр амны тусламж үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавжуулах	Хариуцах байгууллагын төсөв	14.0	-	Шүд, амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр үе шаттайгаар сургалтад хамруулсан байна.	5.0	Халдварын сэргийлэлт, хяналтын сургалтад хамрагдах эмч, эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлсэн байна.	3.0	Халдварын сэргийлэлт, хяналтын сургалтад хамрагдах эмч, эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлсэн байна.	3.0	Халдварын сэргийлэлт, хяналтын сургалтад хамрагдах эмч, эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлсэн байна.	3.0	ЭМХТ, МШМНХ, НАСС	ЭМЯ, НЭМГ, АЭМГ, НАСМСЗ, ОУБ
Зорилт 4. Анхан шатны тусламж үйлчилгээнд Нүүр амны тусламж үйлчилгээг нэвтрүүлэх														
4.1	Амны хөндийн анхан шатны тусламж үйлчилгээний үр дүнтэй загварыг бий болгоход төрийн болон хувийн хэвшлийн амны хөндийн эрүүл мэндийн байгууллагуудыг татан оролцуулах.	ОУБ	20.0	-	Амны хөндийн анхан шатны тусламж үйлчилгээний үр дүнтэй загварыг бий болгоход 5 төрийн болон хувийн хэвшлийн амны хөндийн эрүүл мэндийн байгууллагуудад ухуулга нөлөөллийн ажлыг явуулсан байна.	5.0	Амны хөндийн анхан шатны тусламж үйлчилгээнд төрийн болон хувийн хэвшлийн амны хөндийн эрүүл мэндийн байгууллагууд оролцож, хамтран ажиллаж эхэлсэн байна.	5.0	Амны хөндийн анхан шатны тусламж үйлчилгээнд хамтран оролцох төрийн болон хувийн хэвшлийн амны хөндийн эрүүл мэндийн байгууллагуудын тоог нэмэгдүүлсэн байна.	5.0	Амны хөндийн анхан шатны тусламж үйлчилгээнд төрийн болон хувийн хэвшлийн амны хөндийн эрүүл мэндийн байгууллагууд хамтран ажилласан байна.	5.0	НЭМГ, АЭМГ	ЭМЯ, АЗДТГ, НЗДТГ, ОУБ
4.2	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад шүд цоорох өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, нүүр амны тусламж үйлчилгээг нэвтрүүлэх	ЭМДС	5,304.0	байхгүй	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 20% нь тухайн харьяаны жирэмсэн эмэгтэйчүүд болон 0-18 насны хүүхдүүдийн дунд амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулсан байна.	1,020.0	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 40% нь тухайн харьяаны жирэмсэн эмэгтэйчүүд болон 0-18 насны хүүхдүүдийн дунд амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулсан байна.	1,224.0	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 60% нь тухайн харьяаны жирэмсэн эмэгтэйчүүд болон 0-18 насны хүүхдүүдийн дунд амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулсан байна.	1,428.0	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын +80% нь тухайн харьяаны жирэмсэн эмэгтэйчүүд болон 0-18 насны хүүхдүүдийн дунд амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулсан байна.	1,632.0	ЭМЯ	ЭМДЕГ, НЭМГ, АЭМГ, ОУБ
4.3	0-3 насны хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих, хүүхдийн шүд болон эрүүл мэндийг хамгаалах талаар эцэг эх, асран хамгаалагчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, чадваржуулах ажлыг өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан гэр бүлд суурилсан эрүүл мэндийн боловсролын үйлчилгээг хүргэх.	Улсын төсөв, ОУБ	40.0	-	0-3 насны хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих, хүүхдийн шүд болон эрүүл мэндийг хамгаалах талаар эцэг эх, асран хамгаалагчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, чадваржуулсан байна.	10	0-3 насны хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих, хүүхдийн шүд болон эрүүл мэндийг хамгаалах талаар эцэг эх, асран хамгаалагчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, чадваржуулсан байна.	10	0-3 насны хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих, хүүхдийн шүд болон эрүүл мэндийг хамгаалах талаар эцэг эх, асран хамгаалагчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, чадваржуулсан байна.	10	0-3 насны хүүхдийн амны хөндийн эрүүл ахуйг сахих, хүүхдийн шүд болон эрүүл мэндийг хамгаалах талаар эцэг эх, асран хамгаалагчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, чадваржуулсан байна.	10	НЭМГ, АЭМГ	ЭМЯ, МШМНХ, ОУБ

4.4	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад шүд, амны хөндийн тусламж үйлчилгээг үзүүлэх мэргэжилтнийг ажиллах нөхцөлөөр хангах	-	-	байхгүй	Анхан шатны эрүүл мэндийн 100 байгууллага шүд амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн (Нүүр амны их эмч, эрүүл ахуйч, ОНЭМА) ажиллах нөхцөлийг бүрдүүлж, зохион байгуулалт хийсэн байна.	Анхан шатны эрүүл мэндийн 150 байгууллага шүд амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн (Нүүр амны их эмч, эрүүл ахуйч, ОНЭМА) ажиллах нөхцөлийг бүрдүүлж, зохион байгуулалт хийсэн байна.	Анхан шатны эрүүл мэндийн 250 байгууллага шүд амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн (Нүүр амны их эмч, эрүүл ахуйч, ОНЭМА) ажиллах нөхцөлийг бүрдүүлж, зохион байгуулалт хийсэн байна.	Анхан шатны эрүүл мэндийн 350 байгууллага шүд амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн (Нүүр амны их эмч, эрүүл ахуйч, ОНЭМА) ажиллах нөхцөлийг бүрдүүлж, зохион байгуулалт хийсэн байна.	-	НЭМГ, АЭМГ,	ЭМЯ, ОУБ
4.5	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан амны хөндийн эрүүл мэнд, тусламж үйлчилгээний сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	ОУБ	100.0	-	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан амны хөндийн эрүүл мэнд, тусламж үйлчилгээний сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан амны хөндийн эрүүл мэнд, тусламж үйлчилгээний сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	30.0	30.0	20.0	ЭМХТ, МШМНХ, НАСС	ЭМЯ, НАСМСЗ, ОУБ
Зорилт 5. Нүүр амны тусламж, үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй хүргэх											
5.1	Шүд, амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх	ОУБ	40.0	-	Эрүүл мэндийн байгууллагын халдварын хяналтын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх сургалтын багц боловсруулж, хүргэсэн байна.	Төрийн, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг дэмжлэгт хяналтад хамруулсан байна.	10.0	10.0	10.0	НЭМГ, АЭМГ	ЭМЯ, НАСМСЗ, МШМНХ, ОУБ
5.2	Шүд, амны хөндийн эмгэгийн оношилгоо, эмчилгээний чанарыг сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Хариуцах байгууллагын төсөв	40.0	-	Оношилгоо эмчилгээний стандартуудын 20%-ийг шинэчилж, таниулах сургалт зохион байгуулсан байна.	Оношилгоо эмчилгээний стандартуудын 60%-ийг шинэчилж, таниулах сургалт зохион байгуулсан байна.	10.0	10.0	10.0	НАСМСЗ, МШМНХ	ЭМЯ, НЭМГ, АЭМГ, ОУБ
5.3	Амны хөндийн эмгэгийн илрүүлэг, оношилгоо, эмчилгээнд дижитал технологийн хэрэглээг нэвтрүүлэх	Улсын төсөв, ОУБ	2,000.0	-	Амны хөндийн эмгэгийн Дижитал оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх заавар, журмыг боловсруулж, батлуулсан байна.	Амны хөндийн эмгэгийн оношилгоо, эмчилгээнд Дижитал технологийн хэрэглээг нэвтрүүлж эхэлсэн байна.	500.0	500.0	500.0	НЭМГ, АЭМГ	ЭМЯ, АЗДТГ, НЗДТГ, ОУБ
5.4	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын оношилгоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах	Улсын төсөв	20,000.0	-	Төрийн өмчийн байгууллагуудын шүдний кабинетийн оношилгоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмжийн судалгааг гаргасан байна. Тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулсан байна.	Төрийн өмчийн байгууллагуудын шүдний кабинетийн оношилгоо, эмчилгээний багаж, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулсан байна.	5,000.0	5,000.0	5,000.0	ЭМЯ, НЭМГ, АЭМГ	АЗДТГ, НЗДТГ, ОУБ

5.5	Шүд, амны хөндийн тусламж үйлчилгээг үзүүлэх явуулын багийг төр, хувийн хэвшлийн эмнэлгүүдэд түшиглэн байгуулах, алслагдсан баг, суманд ажиллуулах	Улсын төсөв	4,000.0	-	Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-д явуулын тусламж үйлчилгээ үзүүлэх зориулалтын иж бүрэн тоноглогдсон автомашин үе шаттайгаар нийлүүлж, тусламж үйлчилгээ үзүүлж эхэлсэн байна.	1,000.0	Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-д явуулын тусламж үйлчилгээ үзүүлэх зориулалтын иж бүрэн тоноглогдсон автомашин нийлүүлж, тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	1,000.0	Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-д явуулын тусламж үйлчилгээ үзүүлэх зориулалтын иж бүрэн тоноглогдсон автомашин нийлүүлж, тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	1,000.0	Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-д явуулын тусламж үйлчилгээ үзүүлэх зориулалтын иж бүрэн тоноглогдсон автомашин нийлүүлж, тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	1,000.0	АЭМГ, НЭМГ	ЭМЯ, АЗДТГ, НЗДТГ
5.6	Шүд, амны хөндийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээг санхүүжүүлэх замаар бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг нэмэгдүүлэх	ЭМДС	-	Нэн шаардлагатай тусламж үйлчилгээг ний багц	Эрүүл мэндийн даатгалын сангаас нүүр амны тусламж үйлчилгээнд зарцуулдаг төсвийн зарлага болон гүйцэтгэлийг судалж, илүү боловсронгуй болгосон байна.	-	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих болон нүүр амны суурь тусламж үйлчилгээг бүх насны иргэдэд тохирсон байдлаар хүргэж эхэлсэн байна. Суурь тусламж үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг судалж хамралтыг сайжруулсан байна.	-	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих болон нүүр амны суурь тусламж үйлчилгээг бүх насны иргэдэд тохирсон байдлаар хүргэж эхэлсэн байна. Суурь тусламж үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг судалж хамралтыг сайжруулсан байна.	-	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих болон нүүр амны суурь тусламж үйлчилгээг бүх насны иргэдэд тохирсон байдлаар хүргэж эхэлсэн байна. Суурь тусламж үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг судалж хамралтыг сайжруулсан байна.	-	ЭМДЕГ	ЭМЯ
5.7	Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр, төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн жагсаалтад шүдний эмчилгээний эм, хэрэгслийг оруулах	ЭЭХХЗГ	1,500.0	-	Нүүр амны тусламж үйлчилгээнд ашиглагддаг зайлшгүй шаардлагатай эм, хэрэгслийн жагсаалтыг албажуулсан байна.	-	Нүүр амны тусламж үйлчилгээнд ашиглагддаг зайлшгүй шаардлагатай эм, хэрэгслийг худалдан авалтад хамруулсан байна.	500.0	Нүүр амны тусламж үйлчилгээнд ашиглагддаг зайлшгүй шаардлагатай эм, хэрэгслийг худалдан авалтад хамруулсан байна.	500.0	Нүүр амны тусламж үйлчилгээнд ашиглагддаг зайлшгүй шаардлагатай эм, хэрэгслийг худалдан авалтад хамруулсан байна.	500.0	ЭЭХХЗГ	ЭМЯ, ЭМДЕГ
5.8	Холимог зуулттай хүүхдүүдийн амны хөндийг эрүүлжүүлэх	ЭМДС	12,000.0	-	5-12 насны 30,000 хүүхдүүдийн шүдийг эрүүлжүүлнэ.	3,000.0	5-12 насны 30,000 хүүхдүүдийн шүдийг эрүүлжүүлнэ.	3,000.0	5-12 насны 30,000 хүүхдүүдийн шүдийг эрүүлжүүлнэ.	3,000.0	5-12 насны 30,000 хүүхдүүдийн шүдийг эрүүлжүүлнэ.	3,000.0	ЭМДЕГ, АЭМГ, НЭМГ	ЭМЯ, Төрийн болон хувийн шүдний эмнэлгүүд

Зорилт 6. Амны хөндийн эмгэгийн бүртгэл, тандалтын тогтолцоог бэхжүүлэх

6.1	Амны хөндийн эмгэгийн бүртгэл, мэдээллийн урсгалд үнэлгээ хийх	Улсын төсөв, ОУБ	10.0	-	Амны хөндийн өвчлөлийг бүртгэж, мэдээлж байгаа өнөөгийн байдалд үнэлгээ хийх удирдамж батлагдаж, үнэлгээ хийсэн байна.	5.0	Амны хөндийн өвчлөлийг бүртгэж, мэдээлж байгаа өнөөгийн байдлыг үнэлгээний дүнд зөвлөмж чиглэл гарч, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	5.0	-	-	-	-	ЭМДЕГ, АЭМГ, НЭМГ, ЭМХТ	ЭМЯ, НАСМСЗ, МШМНХ
6.2	Амны хөндийн эмгэгийн бүртгэл, статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох	Улсын төсөв, ОУБ	300.0	-	Амны хөндийн эрүүл мэндийн цахим нэгдсэн мэдээллийг санг хөгжүүлж эхлүүлсэн байна.	100.0	Амны хөндийн эрүүл мэндийн цахим нэгдсэн мэдээллийг санг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	100.0	Амны хөндийн эрүүл мэндийн цахим нэгдсэн мэдээллийг санг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	50.0	Амны хөндийн эрүүл мэндийн цахим нэгдсэн мэдээллийг санг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	50.0	ЭМДЕГ, АЭМГ, НЭМГ, ЭМХТ	ЭМЯ, НАСМСЗ, МШМНХ
6.3	Төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээг хамарсан амны хөндийн эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох	-	-	-	Хувийн болон төрийн өмчит эмнэлгийн үзүүлсэн НАТУ-ний мэдээллийг нэгтгэж ЭМХТ-д тогтмол хүргүүлдэг болсон байна.	-	Хувийн болон төрийн өмчит эмнэлгийн үзүүлсэн НАТУ-ний мэдээллийг нэгтгэж ЭМХТ-д тогтмол хүргүүлдэг болсон байна.	-	Хувийн болон төрийн өмчит эмнэлгийн үзүүлсэн НАТУ-ний мэдээллийг нэгтгэж ЭМХТ-д тогтмол хүргүүлдэг болсон байна.	-	Хувийн болон төрийн өмчит эмнэлгийн үзүүлсэн НАТУ-ний мэдээллийг нэгтгэж ЭМХТ-д тогтмол хүргүүлдэг болсон байна.	-	АЭМГ, НЭМГ, ЭМХТ	ЭМЯ, НАСМСЗ, МШМНХ
6.4	Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчний хяналт, тандалт хийж жил бүр "Эрүүл мэндийн үзүүлэлт"-д тусгах	-	-	-	Амны хөндийн эрүүл мэндийн мэдээллийг нэгтгэн, жил бүрийн ЭМХТ-ийн гаргадаг "Эрүүл мэндийн үзүүлэлт"-д тусгасан байна.	-	Амны хөндийн эрүүл мэндийн мэдээллийг нэгтгэн, жил бүрийн ЭМХТ-ийн гаргадаг "Эрүүл мэндийн үзүүлэлт"-д тусгасан байна.	-	Амны хөндийн эрүүл мэндийн мэдээллийг нэгтгэн, жил бүрийн ЭМХТ-ийн гаргадаг "Эрүүл мэндийн үзүүлэлт"-д тусгасан байна.	-	Амны хөндийн эрүүл мэндийн мэдээллийг нэгтгэн, жил бүрийн ЭМХТ-ийн гаргадаг "Эрүүл мэндийн үзүүлэлт"-д тусгасан байна.	-	АЭМГ, НЭМГ, ЭМХТ	ЭМЯ, НАСМСЗ, МШМНХ

6.5	Их дээд сургуулиуд нүүр амны эрүүл ахуй, нийгмийн эрүүл мэндийн судалгааны хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх	Эрүүл мэндийг дэмжих сан, ОУБ	600.0		Нүүр амны их эмч бэлтгэдэг төрийн болон хувийн их дээд сургууль, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд нүүр амны эрүүл ахуй, нийгмийн эрүүл мэндийн судалгааны хөтөлбөрийг баталсан байна.	150.0	Нүүр амны их эмч бэлтгэдэг төрийн болон хувийн их дээд сургууль, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд нүүр амны эрүүл ахуй, нийгмийн эрүүл мэндийн судалгааны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна	150.0	Нүүр амны их эмч бэлтгэдэг төрийн болон хувийн их дээд сургууль, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд бүгд нүүр амны эрүүл ахуй, нийгмийн эрүүл мэндийн судалгааны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	150.0	Нүүр амны их эмч бэлтгэдэг төрийн болон хувийн их дээд сургууль, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд бүгд нүүр амны эрүүл ахуй, нийгмийн эрүүл мэндийн судалгааны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	150.0	ЭМЯ, БЕГ	Төрийн болон хувийн их, дээд сургуулиуд
6.6	Амны хөндийн эрүүл мэндийн үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулах	Холбогдох байгууллагууд, ОУБ	600.0		Амны хөндийн эрүүл мэндийн үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.	150.0	Амны хөндийн эрүүл мэндийн үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.	150.0	Амны хөндийн эрүүл мэндийн үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.	150.0	Амны хөндийн эрүүл мэндийн үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.	150.0	МШМНХ	ЭМЯ, НЭМГ, АЭМГ, НАСМСЗ, ОУБ

Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 1/25/А/25 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

"Эрүүл шүд" арга хэмжээний төлөвлөгөө /2024-2027/-ний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

д/д	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2022 он	Хүрэх түвшин				Мэдээллийн эх үүсвэр
			2024 он	2025 он	2026 он	2027 он	
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт							
1.	Шүдний урьдчилсан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоонд тухайн жил хамрагдсан хүүхдийн тоо	200,000	100,000	150,000	200,000	300,000	ЭМДЕГ
2.	Шүдний урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээнд хамрагдсан, нэмэлт эрдэсжүүлэлт хийлгэсэн хүүхдийн тоо	-	500	600	700	800	ЭМДЕГ
3.	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд өдрийн цайны дараа "Шүд угаах" цагийг хэрэгжүүлдэг болсон боловсролын байгууллагуудын эзлэх хувь	2	20	40	60	80	БШУЯ
4.	Дижитал технологи ашиглан амны хөндийн эмгэгийг эрт илрүүлэх, оношлох, эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо	-	100,000	200,000	300,000	400,000	НЭМГ, АЭМГ
5.	Нүүр амны тусламж, үйлчилгээний халдвар хамгаалал, чанар аюулгүй байдлын чиглэлээр чадавхжуулсан эмч, мэргэжилтнүүдийн тоо	50	300	400	500	600	ЭМЯ
6.	Амны хөндийг эрүүлжүүлсэн 5-12 насны хүүхдийн тоо	5000	30,000	30,000	40,000	40,000	ЭМДЕГ

д/д	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2022 он	Хүрэх түвшин				Мэдээллийн эх үүсвэр
			2024 он	2025 он	2026 он	2027 он	
7.	6 настай хүүхдийн дунд шүд цоорох өвчний тархалтын эзлэх хувь	87.6	87.0	86.4	86.0	85	НАСМСЗ
8.	6 настай хүүхдийн дунд шүд цоорох өвчний ЦЛ (цоорсон, ломбодсон шүдний тоо)	6.2	6.0	5.5	5.2	5.0	НАСМСЗ
9.	12 настай хүүхдийн дунд шүд цоорох өвчний тархалтын эзлэх хувь	77	76	75	74	73	НАСМСЗ
10.	12 настай хүүхдийн дунд шүд цоорох өвчний ЦЛ (цоорсон, ломбодсон шүдний тоо)	2.2	2.1	2.0	1.9	1.8	НАСМСЗ
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт							
11.	Боловсролын байгууллагын шинээр байгуулсан шүд угаах цэгийн тоо	2	90	114	114	114	БШУЯ
12.	“Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих нь” сэдвээр сургалтад хамрагдсан цэцэрлэг, ЕБС-ийн багш нарын тоо	0	300	400	500	600	БШУЯ
13.	Нийгмийн эрүүл мэнд, менежмент, манлайллын чиглэлээр бэлтгэгдсэн Нүүр ам судлалын салбарын эмч, мэргэжилтнүүдийн тоо	1	10	15	20	25	ЭМЯ
14.	Нүүр амны тусламж, үйлчилгээг анхан шатанд хүргэж эхэлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	0	100	150	250	350	НЭМГ, АЭМГ
15.	Дижитал технологийг нүүр амны тусламж, үйлчилгээнд нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	0	100	150	250	350	НЭМГ, АЭМГ

---oOo---